



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 12 өдөр

Дугаар Б/98

Бодь

Засаг даргын Тамгын газрын дарга
З.Цэрэндоржийг үндсэн ажилд нь
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1.22, Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 60.1.2, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 2.10, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, өөрийн хүсэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын дарга З.Цэрэндоржийг 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс үндсэн ажилд нь томилсугай.


2.Засаг даргын Тамгын газрын дарга З.Цэрэндоржийн сарын үндсэн цалинг ТЗ-9-5 дахь шатлал 1.045,653 (нэг сая дөчин таван мянга зургаан зуун тавин гурав) төгрөгөөр тогтоосугай.

3.З.Цэрэндоржид ажилласан жилийн нэмэгдэл 25 хувь, зэрэг дэвийн нэмэгдэл 30 хувь, нууцын нэмэгдэл 10 хувь, авлигатай тэмцэх газрын 2012 оны 96 дугаар тогтоолын 2.3 дахь заалтын дагуу 10 хувийн нэмэгдлийг тус тус олгосугай.

4.З.Цэрэндоржийн үндсэн цалин, нэмэгдлийг тогтоосон хувь хэмжээгээр 2021 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн бодож олгохыг Нягтлан бодогч (Б.Батбаяр)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Сумъяа)-д даалгасугай.

ДАРГА



Р.БАТЖАРГАЛ

642201189